



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/41

Сангийндалай

Сумын төвийн худгийн засвар, үйлчилгээ,
тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг хяналт тавин хүлээн
авах ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа.ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дугаар зүйлийн 2.10 дахь заалт Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулах журмын 9.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сумын төвийн худгийн засвар, үйлчилгээ, тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг хүлээн авч, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: О.Базаррагчаа (Засаг даргын орлогч)


Гишүүдэд: Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

М.Эмүүжин (Засаг даргын Тамгын газрын нярав)

Ж.Түвшинбаатар (7-р багийн Засаг дарга)

Д.Ядамжав (Засаг даргын Тамгын газрын жолооч)

2. Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавин хүлээж авахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Г. ЭНХДЭЛГЭР

